

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВД БАЙРЛАЖ БУЙ ИРГЭДИЙН
2025 ОНЫ I УЛИРЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН ДҮГНЭЛТ

2025 оны 03 дугаар сарын 25

Улаанбаатар

хот

ЗОРИЛГО: Нийгмийн хамгааллын тусгай төвийн үйлчилгээний чанар хүртээмж болон албан хаагчдын харилцаа хандлагыг үнэлэх.


ХАМРАХ ХҮРЭЭ: Нийгмийн хамгааллын тусгай төвөөс түр хоноглох байрны үйлчилгээ авч буй иргэд.

АСУУЛГЫН БҮТЭЦ: Сэтгэл ханамжийн судалгаа нь нийт 10 асуулттай. Үүний 1 нь хаалттай асуулт, 8 нь хагас хаалттай асуулт, 1 нь нээлттэй асуулт байв.

СУДАЛГААНД ОРОЛЦОГЧ: Судалгаанд нийт 33-66 насны 40 иргэн хамрагдсан бөгөөд үүний 7 нь эмэгтэй, 33 нь эрэгтэй оролцогч байв.

1. Нийгмийн хамгааллын тусгай төвөөр хэр удаан үйлчлүүлж байна вэ? Гэсэн асуултын хариултыг график 1-т харууллаа.


График 1



Судалгаанд оролцсон иргэдийн 70% нь нийгмийн хамгааллын тусгай төвөөс 1 жил хүртэлх хугацаагаар үйлчилгээ авч байгаа бол 27% нь 2-5 жил хүртэлх хугацаагаар үйлчилгээ авч байгаа харин үлдсэн 3% нь 6-9 жил үйлчилгээ авч буй иргэд байв.

2. Нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эмч, байрны багш, жижүүр, тогоочийн ажил үйлчилгээний чанар хүртээмжид хэр сэтгэл хангалуун байгаа талаарх асуултыг 3,4,5,6,7,8 -дугаар асуултад тусгасан ба өгсөн хариултыг график 2-оос харна уу.


График 2



Судалгаанд оролцогчдын 82% нь нийгмийн ажилтнуудын үйл ажиллагааг маш сайн гэж үнэлсэн бол 18% нь хангалттай хэмээн үнэлсэн. Харин сэтгэл зүйчийн ажил үйлчилгээг 88% нь маш сайн, 12% нь хангалттай, эмчийн ажил үйлчилгээг 75% нь маш сайн, 25% нь хангалттай, байрны багшийн ажил үйлчилгээг 80% нь маш сайн, 20% нь хангалттай гэж үнэлсэн. Түүнчлэн жижүүрийн ажил үйлчилгээг 80% нь маш сайн, 20% нь хангалттай, тогоочийн үйл ажиллагааны чанар хүртээмжийг 58% нь маш сайн, 40% нь хангалттай, 2% нь хангалтгүй гэж тус тус үнэлсэн байна.

3.Төвийн ая тухтай байдал болон албан хаагчдын харилцаа хандлагыг үнэлэхэд чиглэсэн 2 болон 9 дүгээр асуултад өгсөн хариултын үр дүнг график 3-аас харна уу.

График3



Төвийн байрны ая тухтай байдлыг иргэдийн 70% нь маш сайн, 30% нь хангалттай гэж үнэлсэн. Албан хаагчдын харилцаа хандлагад өгсөн үнэлгээгээр иргэдийн 73% нь харилцаа

хандлага маш сайн, 25% нь хангалттай гэсэн хариултыг өгсөн бол 2% нь хангалтгүй буюу иргэдийг заримдаа ялгаж харьцдаг гэсэн хариултыг өгсөн.

4. Тус төвийн үйл ажиллагааг та цаашдаа ямар байгаасай гэж хүсэж байна вэ? Гэсэн нээлттэй асуултын хариултыг хүснэгтэд харуулав.

Жич:Судалгаанд судлаачийн зүгээс субъектив нөлөөлөл оруулахгүйн тулд үйлчлүүлэгч иргэдээс ирсэн санал хүсэлт, шүүмж, талархлын үг өгүүлбэрийг засваргүйгээр оруулсан болно.

Хүснэгт 1

	Санал, хүсэлт	Шүүмж	Талархал
1	Энд ирж буй хүмүүст үнэн чин сэтгэлээсээ ханддаг шигээ л байгаарай.		Миний хувьд боломжоороо сайхан байна. Та бүхний амьдралд сайн сайхныг хүсэн ерөөе.
2	Цаашид номын сан хэрэгтэй гэж бодож байна.		Цаашдаа ч гэсэн энэ хэвээрээ явбал болно. Нийт ажилчид албан хаагчдад ажлын амжилт хүсье.
3	Удахгүй нүүж шинэ орчинд очих тул нийгэмд идэвхтэй тэмцээн болон урлаг соёлын ажиллагааг хөгжүүлэн бие биедээ урам өгч ажиллаж амьдрахыг хүсэж байна.		Тус төвийн үйлчилгээ надад маш их таалагддаг. Сэтгэл санаа маш өндөр мөн эрүүл саруул эрч хүчийг авч байдагт баяртай байна.
4	Тус төвийн үйлчилгээг төр засгийн зүгээс дэмжиж туслалцаа үзүүлбэл сайн байна.		Хамт олонд амжилт хүсье.
5	Тус төвийн үйл ажиллагаа цаашдаа бүр маш сайхан олон хүнтэй байгаасай гэж хүсэж байна.		
6	Бусдын төлөө илүү эрчимтэй байж зөв ёс суртахуунтай болгож өгөөрэй.		
7	Одоогийн үйлчилгээг улам их сайжруулаарай. Миний хувьд одоогийн үйлчилгээ сайн байна.		
8	Үргэлжлүүлэн үйл ажиллагаагаа явуулж байвал сайн байна.		
	Санал, хүсэлт- 8	Шүүмж-0	Талархал- 4

ДҮГНЭЛТ

Нийгмийн хамгааллын тусгай төвөөс үйлчилгээ авч буй иргэдээс 2025 оны I улирлын сэтгэл ханамжийн судалгааг авсан бөгөөд судалгаанд 33-66 насны нийт 40 иргэн хамрагдсаны 33 нь эрэгтэй, 7 нь эмэгтэй иргэн байсан. Уг сэтгэл ханамжийн судалгааны зорилго нь төвийн үйл ажиллагааны чанар, хүртээмжийг үнэлэх явдал байсан бөгөөд судалгаанд байгууллагын нийт ажилчдын ажлын чанар хүртээмжийг үнэлэх 7 асуулга, төвийн ая тухтай байдлыг үнэлэх 1 асуулга, үйлчилгээ авч буй иргэдийн үйлчлүүлсэн хугацааг илрүүлэх 1 асуулга болон иргэдээс хэлэх санал хүсэлтийг сонсох 1 задгай асуулт бүхий нийт 10 асуулгаар судалгааг авсан.

Судалгаанд хамрагдсан иргэдийн 70% нь НХТ Төвөөс нэг жил хүртэлх хугацаагаар үйлчилгээ авч буй иргэд байсан бол 28% нь 2-5 жил, харин үлдсэн 2% нь 6-9 жил үйлчилгээ авч буй иргэд байсан. Судалгааны үр дүнгээр байгууллагын нийт албан хаагчдын ажил үйлчилгээний чанар хүртээмж болон иргэдтэй харилцаж буй харилцаа хандлагад нийт иргэдийн 76% нь маш сэтгэл хангалуун байгаа гэсэн хариултыг өгсөн бол үлдсэн 24% нь үүнийг хангалттай байгаа хэмээн үнэлсэн. Байгууллагын орчин нөхцөлийн ая тухтай байдлыг үнэлэх асуулгад иргэдийн 70% маш сэтгэл хангалуун, үлдсэн 30% нь хангалттай гэсэн үнэлгээг өгсөн.

Иргэдийн санал хүсэлт, шүүмж, сайшаалыг тодорхойлох задгай асуулгын хэсэгт 8 санал хүсэлт, 3 талархал ирсэн ба шүүмж ирээгүй. Иргэдээс ирсэн санал хүсэлт нь байгууллагын одоо явуулж буй үйл ажиллагааг цаашид илүү олон хүнд хүрч, өргөжин тэлж ажиллаасай гэсэн хүсэлтэй байсан. Мөн байгууллагын хамт олонд аз жаргал, ажлын амжилт хүссэн талархал тус тус ирсэн.

Судалгааны эцсийн үр дүнгээр Нийгмийн хамгааллын тусгай төвийн үйл ажиллагаа, ажилчдын ажил үйлчилгээ, харилцаа хандлага, төвийн ая тухтай байдал нь өмнөх оны IV улирлын сэтгэл ханамжийн судалгаатай харьцуулахад сайжирсан буюу үйлчилгээ авч буй иргэдийн сэтгэл ханамж өндөр байгаа гэсэн үр дүн гарсан.

ХЯНАСАН
АХЛАХ АРГА ЗҮЙЧ

М.МӨНХСАЙХАН

ТАЙЛАН ГАРГАСАН:
СЭТГЭЛ ЗҮЙЧ

С.ОЮУННОМИН